



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 01 сарын 02 өдөр

Дугаар А/05

Мандалговь

“Шилдэг эцэг эхийн зөвлөл”-ийг
алдаршуулах тухай

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, 15.1.5, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.5, 18.1.6, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн “Хүүхэд хамгааллын чиглэлээр баримтлах бодлого, чиглэл батлах тухай” 03 дугаар тогтоол, Төсвийн шууд захирагчаас Төрийн жинхэнэ албан хаагчтай байгуулсан 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.1.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гэр бүл, нийгмийн хүрээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, хүүхдийг эрсдэлт нөхцөлд орохоос урьдчилан сэргийлэх, хамгаалахад хүлээсэн үүрэг хариуцлагаа биелүүлэх, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх, эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор зохион байгуулагдсан “Хүүхэд бүрийн төлөө, Хариуцлагатай байя” аянд идэвх санаачлага гаргаж манлайлан ажилласан байгууллагын эцэг эхийн зөвлөлийг алдаршуулах үйл ажиллагааг 2022 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн дотор зохион байгуулсугай.

2. “Шилдэг эцэг эхийн зөвлөл”-ийг алдаршуулах үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийг 1 дүгээр, шаардагдах төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Үйл ажиллагаанд шаардагдах 1,275,000 (Нэг сая хоёр зуун далан таван мянга) төгрөгийг Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрөөс санхүүжүүлэхийг Нягтлан бодогч (С.Чинбат)-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтийг хангаж, үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, Гэр бүлийн асуудал хариуцсан мэргэжилтэн (Б.Бүжинлхам)-д үүрэг болгосугай.

5. Үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн дотор Даргын дэргэдэх зөвлөлд танилцуулахыг Гэр бүлийн асуудал хариуцсан мэргэжилтэн (Б.Бүжинлхам), гишүүдэд даалгасугай.


ДАРГА



Ц.ГАНЗОРИГ

482201009

Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд,
залуучуудын хөгжлийн газрын даргын
2022 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн
№/05 тоот тушаалын 01 дүгээр хавсралт



**"ШИЛДЭГ ЭЦЭГ ЭХИЙН ЗӨВЛӨЛ" АЛДАРШУУЛАХ
ҮЙЛ АЖИЛЛАГАА ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ**

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Бүжинлхам

(Гэр бүлийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд:

Х.Төмөрбат

(Залуучуудын хөгжлийн салбар зөвлөл, хамтын
ажиллагаа хариуцсан ажилтан)

Д.Мигар

(Хамгаалах байрны арга зүйч, сэтгэл зүйч)

Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд,
залуучуудын хөгжлийн газрын даргын
2022 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн
А/05 тоот тушаалын 08 дүгээр хавсралт



**“ШИЛДЭГ ЭЦЭГ ЭХИЙН ЗӨВЛӨЛ” АЛДАРШУУЛАХ
ҮЙЛ АЖИЛЛАГААНД ШААРДАГДАХ ТӨСӨВ**

№	Зардлын ангилал	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ	Тоо ширхэг	Нийт үнэ
1	Өргөмжлөл	ш	50,000	5	250,000
2	Мөнгөн шагнал	ш	200,000	5	1,000,000
3	Батламж	ш	5,000	5	25,000
Нийт					1,275,000

---oOo---